

ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ

2016 оны 11-р сарын 28-ны өдөр

Зуунмод

Нэг. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д заасны дагуу аймгийн орон нутгийн 2017 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулан оруулж байна.

Орлого: Аймгийн Засаг даргын өргөн барьсан 2017 оны төсвийн төсөлтэй танилцахад Сангийн яам орон нутгийн төсвийн суурь орлогыг 11651.7 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн нь 2016 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 685.0 сая төгрөг буюу 5.9 хувиар, ХБГ-ээс 1035.5 сая төгрөг буюу 8.8 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэс Сангийн яамны хянасан орлогын төлөвлөгөөг 890.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 12542.7 сая төгрөгөөр төлөвлөн ИТХуралд оруулсан байна. Орлогыг нэмэгдүүлэн төлөвлөснийг 2016 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулахад 206.0 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

Аймгийн 2017 оны орлого, санхүүжилт дараах байдлаар төлөвлөгдсөн байна. Үүнд:

• Сумдын орон нутгийн төсвийн орлого	2016.4 сая төгрөг
• Аймгийн төвлөрсөн төсвийн орлого	10526.2 сая төгрөг
Орон нутгийн орлогын дүн	12542.6 сая төгрөг
• Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	7577.1 сая төгрөг
• Тусгай зориулалтын шилжүүлгээр олгох санхүүгийн дэмжлэг	41821.5 сая төгрөг
• Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	3547.9 сая төгрөг
Аймгийн 2016 оны нийт орлого, санхүүжилтийн дүн	65489.1 сая төгрөг

Зарлага: Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар Төв аймгийн 2017 оны төсвийн нийт зарлага **64598.2** сая төгрөг, үүнээс орон нутгийн суурь зарлага 19228.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зарлага 41821.5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн зарлага 3547.9 сая төгрөг байхаар батлагдсан байна.

Аймгийн Засаг даргын өргөн барьсан 2017 оны төсвийн төслөөр орон нутгийн төсвийн зарлагыг 890.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 20119.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зарлага 41821.5 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн зарлага 3547.9 сая төгрөг байхаар тооцож нийт зарлагыг **65489.1** сая төгрөгөөр тооцон ИТХ-д оруулсан байна.

Орон нутгийн байгууллагуудын зарлага 2016 оны тодотгосон төлөвлөгөөгөөр 21369.6 сая төгрөг байсан бол 2017 оны төсвийн төсөлд 20119.8 сая төгрөг буюу 1249.8 сая төгрөгөөр буурч тооцогдсон байна. Тусгай зориулалтын шилжүүлэгийн төсөвт байгууллагуудын 2017 оны нийт зарлага 41821.5 сая төгрөг байхаар батлагдсан нь 2016 оны төлөвлөгөөнөөс 1127.1 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар нэмэгдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сан 3547.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөн нь 2016 оны батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 3384.3 сая төгрөг буюу 53.7 хувиар буурсан байна.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн зардалд улсын төсвөөс 3547.9 сая төгрөг хуваарилагдснаас 631.3 сая төгрөгийг урсгал зардалд, 2916.6 сая төгрөгийг аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар тооцогдсон байна. 2017 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд 1302.4 сая төгрөг буюу 44.6 хувь, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 1614.1 сая төгрөг буюу 55.3 хувь нь хувиарлагдахаар тооцогджээ.

Нийт зардлын бүтцийг авч үзвэл:

• Сумдын зарлага	10144.6 сая төгрөг
• Аймгийн төсвийн зарлага	9975.1 сая төгрөг
• Орон нутгийн хөгжлийн сангийн зарлага	3547.9 сая төгрөг
• Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зарлага	41821.5 сая төгрөг
Нийт дүн	65489.1 сая төгрөг

Аймгийн төсөвт нэмж тооцсон 890.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээс дараахь зардлуудад хувиарлахаар тооцсон байна.

- Аймгийн ИТХ-ын Ажлын албаны цалин, НДШимтгэлд 20.0 сая төгрөг
- Сумдын ИТХ-ын цалин, НДШимтгэлд 97.1 сая төгрөг
- Сумын ЗДТГазрын цалин, НДШимтгэлд 115.7 сая төгрөг
- Сумын ЗДТГ-ын бусад хувьсах зардалд 105.4 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ-ын цалин, ндш зардалд 44.9 сая төгрөг
- Санхүүгийн хяналт,аудитын албаны цалин, тогтмол зардалд 14.4 сая төгрөг
- Байгаль орчин аялал, жуулчлалын газрын цалин, ндш, бусад зардалд 22.9 сая төгрөг
- Орон нутгийн өмчийн газрын цалин, ндш, тогтмол зардалд 49.1 сая төгрөг
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн албаны зардалд 40.4 сая төгрөг
- Хот тохижуулах газрын цалин, хувьсах зардалд 32.8 сая төгрөг
- Аймгийн орон нутгийн Замын санд 62.5 сая төгрөг
- Сумдын хог хаягдал зайлуулах зардалд 106.0 сая төгрөг
- Сумын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 41.6 сая төгрөг
- Аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй зардалд 138.1 сая төгрөг

Хоёр. Төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэж үр ашиг дээшлүүлэх талаар

Төсвийн орлого нэмэгдүүлэх талаар:

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д аймгийн Аудитын газар нь “Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймгийн ИТХуралд оруулах бүрэн эрхтэй” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн төсөлд холбогдох тооцоо, судалгаа хийлээ.

Өнгөрсөн онд аймгийн 2016 оны төсвийн төсөлд Аудитын газраас төсвийн орлогыг 1767.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал боловсруулан аймгийн ИТХуралд оруулж улмаар хурлаас гарах тогтоол, шийдвэрт тусгуулж байсан. Аймгийн хэмжээнд төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлж, татварыг бүрэн ногдуулан ажиллахад тодорхой хэмжээний нөөц боломж байгаа нь орлогын төлөвлөгөөний биелэлт болон төсвийн шилжих үлдэгдэлээр харагдаж байна.

Төрийн аудитын байгууллага хийсэн тооцоо, судалгаандаа үндэслэн аймаг, сумдын төсвийн орлогыг нийт 2194.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тооцох боломж байна гэж үзсэнээ танилцуулья.

Аймгийн төсвийн орлогод Үл хөдлөх хөрөнгийн татварыг 220.0 сая төгрөгөөр, Газрын төлбөрийг 277.8 сая төгрөгөөр, Ус ашигласны төлбөрийг 282.3 сая төгрөгөөр, Өмч хувьчлалын орлогыг 80.0 сая төгрөгөөр, Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 8.3 сая төгрөгөөр, Нэр зааж ангилагдаагүй орлогыг 500.0 сая төгрөгөөр, ОНХөрөнгө борлуулсны орлогыг 300.0 сая төгрөгөөр нийт 1668.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийлээ.

Сумдын орон нутгийн орлогод Хувь хүний орлогын албан татварыг /суутган2/ 160.0 сая төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 44.9 сая төгрөгөөр, Ус ашигласны төлбөрийг 69.7 сая төгрөгөөр, Хог хаягдлын хураамжийн орлогыг 199.3 сая төгрөгөөр, Түрээсийн орлогыг 52.4 сая төгрөгөөр, нийт 526.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

/Хавсралтаар харуулав./

Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 77 дугаар тогтоол, 2015 оны 01 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2013 оны а/448, а/582 тоот захирамжуудын хүрээнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалгүй олгосон газрын дуудлага худалдааны анхны үнийг Нэр зааж ангилагдаагүй орлогот төвлөрүүлж байгаад 2015 оны 6 сараас эхлэн ОНХСангийн орлогот шууд төвлөрүүлж байна. Энэ төрлийн орлогоор ОНХСангийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр хуулинд заагдаагүй байна. Иймд Газрын тухай хууль тогтоомж болон аймгийн ИТХурал, Засаг даргын гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажилласнаар газрын дуудлага худалдааны анхны үнийг нэр зааж ангилагдаагүй орлогот төвлөрүүлэх шаардлагатай байна. Судалгаагаар энэ төрлийн орлогоор 8388.9 сая төгрөг орох боломж байна, үүнээс сүүлийн жилүүдийн хэрэгжилтийн явцыг харгалзан 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал оруулж байна.

Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын орлогын ногдуулалтанд үндэслэдэггүй өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөж байгааг орлогын суурь судалгаанд үндэслэн төлөвлөдөг болох, мөн татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, татварын бааз суурийг тэлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар:

Төсвийн тухай хуульд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлын үр ашгийг сайжруулах, төсвийн зардлыг хэмнэх, үйл ажиллагааны орлогоо давуулан биелүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, уян хатан захиран зарцуулах эрх олгохын зэрэгцээ, сахилга хариуцлагыг бүх түвшинд сайжруулах талаар тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

Аймгийн 2017 оны төсвийн төсөлд ОНХСан, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэснийг баримтлан ажиллах шаардлагатай байна.

Гурав. Санал, дүгнэлт

Төв аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн төслийн орлогыг Сангийн яамнаас 11651.6 сая төгрөгөөр хянаж ирүүлсэнийг аймгийн Засаг дарга 890.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 12542.6 сая төгрөгөөр тооцож ИТХуралд өргөн барьжээ.

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орлого нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийн аймгийн 2017 оны төсвийн төсөлд орлогыг 2194.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх нөөц бололцоо байна гэж үзэн санал, дүгнэлтээ оруулж байна.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

№	Орлогын нэр төрөл	төсвийн төсөл	нэмэгдүүлэх санал	нэмэгдэх дүн	Тайлбар үндсэлэл
Сумын орон нутгийн орлого					
1	Хувь хүний орлогын албан татвар Суутган -2	199.1	160.0	359.1	Орлого нэмэгдүүлэх талаар судалгаа хийх явцад Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүртгэлийн мэдээллийн дүнгээр сүүлийн жилүүдэд бэлэглэлийн гэрээгээр үл хөдлөх хөрөнгийг өмчлөгчийнх нь эрхийг шилжүүлэх нь нэмэгдсэн байна. Энэ нь үл хөдлөх хөрөнгө шилжилт хөдөлгөөн нэг талаас ихэсч байгаа боловч нөгөө талаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого”-д уг хуулийн 23.2.1-д заасан 2 хувиар албан татвар ногдуулж, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1-д заасны дагуу сумдын төсвийн орлогод оруулахаас зайлсхийж байна гэж үзэж болохоор байгааг хэлэх нь зүйтэй байна. Тухайлбал: 2015-2016 онд 925.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн байна. 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль хүчингүй болсноор уг хуулиар татвар төлөгчид Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвараа төлөх ёстой. Гэтэл хуучин жишиг татвараар төлүүлэх дутагдал байсаар байна. Орлогыг тодорхойлохын тулд хэрэгжүүлж буй Худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд нь худалдан авагч нартаа татварын нэгдсэн системээр баталгаажсан сугалаа бүхий баримтыг хэвлэж өгөх үүрэгтэй. Гэтэл Зуунмод сумын тоотой хэдэн дэлгүүр, ШТС, үйлчилгээний газрууд нь кассын машин хэвлэх төхөөрөмж байршуулсан байгаа ч болохгүй, эдвэрсэн, сүлжээгүй байна гэсэн тайлбараар хэвлэж өгөхгүй нэг талаар иргэдийг хохироож нөгөө талаар орлогоо нуух арга хайж байна. Мөн сумд болон жижиг дэлгүүр, аж ахуйн нэгж бүр өнөөдөр дээрх кассын машингүй иргэдэд үйлчилж байна. Иргэдийн хувьд www.ebarimt.mn сайтад нэвтэрч бүртгүүлэх процесс нь хүндрэлтэй тул ихэнх иргэд ач тусыг мэдэхгүй баримтаа авахгүй, үйлчилгээ эрхлэгч өгөхгүй хэвшмэл байдал тогтлоо. Иймээс хуулийг суртчлах, түүнд хяналт шалгалт тавьж ажиллавал орлого нэмэгдэх бүрэн боломжтой байна. СЯмнаас 2017 онд уг суурь орлогыг 118.2 сая төгрөгөөр баталсан ба 2016 оны ХБГүйцэтгэлээр 280.2 сая төгрөг байгаа тул суурь орлогыг 160.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 278.2 сая төгрөг болгох боломжтой байна.

2	Улсын тэмдэгтийн хураамж	101.1	44.9	146.0	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.4-35.1.22, 35.2-35.5 дах заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын 2011.09.29 ны өдрийн 13-р хуралдааны 03 тоот тогтоолоор тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон. Дээрхи тогтоолын 1.11-д мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой малд 1000 төгрөг, 10-аас дээш тооны толгой мал бол 1000 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд 50 төгрөг нэмж авахаар шийдвэрлэсэн. Гэтэл сумдын Мал үржлийн алба нь төв суурин газарт худалдан борлуулахар оруулж байгаа малд гарал үүслийн гэрчилгээг бичиж тэмдэгтийн хураамж авахгүй байна. Орон нутгийн төсөвт орох улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг оруулахгүй байгаа нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.14 дэх заалт болон аймгийн ИХТ-ын дээрхи шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байна. Аймгийн Статистикийн хэлтсийн судалгаагаар сүүлийн 3 жилийн дундажаар тооцоход малчин өрх хонин толгойд шилжүүлснээр 449.9 мянган толгой мал зах зээлд худалдан борлуулсан байна. Дээрхи статистикийн тоонд үндэслэн тооцоход жилд 44.9 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж орох нөөц боломж байна.
3	Ус ашигласны төлбөр	18.3	69.7	88.0	Ус ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхдээ зөвхөн урьд оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцож нэмэгдүүлсэн. Жишээлбэл: Эрдэнэ сумын татварын байцаагчийн 2016 онд ус ашиглагчидад хийсэн ногдуулалтыг төсвийн төсөлд тусгахдаа -Рашааны төлбөрийг 5 аж ахуйн нэгжид 23.7 сая төгрөг ногдуулсаныг 4 аж ахуйн нэгжид 22.5 сая төгрөг буюу 1.1 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн -Ус ашиглагч нарын судалгаар 40 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс сум 17 аж ахуйн нэгжид ногдуулалт хийж ирсэнийг 14 аж ахуйн нэгжийн ногдуулалтаар аймгийн орлогын мэргэжилтэн орлогоо тус тус зөрүүтэй тооцож байгаа нь орлогыг бүрэн төлөвлөж эх үүсвэрийг бүрдүүлж чадахгүй байна. Иймд дутуу төлөвлөгдсөн усны төлбөрийг орон нутгийн орлогод 69.7 сая төгрөг нэмэгдүүлэх боломжтой байна.
4	Хог хаягдлын хураамжийн орлого	166.9	199.3	366.2	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай хууль, аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 15-р тогтоолыг үндэслэн хог хаягдлын хураамжийн хэмжээ сум тус бүрийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолуудыг үндэслэж тооцож гаргасан. Судалгаанд сумын төвийн айл өрхийн тоог хөдөөний багийн айлуудын хөдөлгөөнөөс хамааруулж 65%-иар тооцоход нийт 220.5 сая төгрөг, төсөвт байгууллагуудаас 25.0 сая төгрөг, аж ахуйн нэгж байгууллагаас 120.7 сая төгрөг буюу нийт 366.2 сая төгрөгийн хог хаягдлын татварын орлого төвлөрүүлэх боломжтой байна.
5	Түрээсийн орлого	37.0	52.3	89.3	Төрийн байгууллагын байранд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшил болох Ажилд жуучлал эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Оюунлаг өөрчлөлт төрийн бус байгууллага, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага, Төмөр трейд ХХК, Солонго цогцолборт үйл ажиллагаа явуулж буй Скайтел ХХК, Зуунмод сумын ЗДТГ-ын Нэг цэгийн нотриат, Хаан банк, 5-р сургуулийн Үдийн цай нийлүүлдэг иргэн зэргийн түрээсийн орлогыг аймгийн ИТХ-ын 2010 оны 01-р сарын 25 өдрийн 10-р тогтоолоор тогтоосон тарифын дагуу тооцоход 52.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
дүн		522.4	526.2	1048.6	

Аймгийн төсвийн орлого

1	ҮХЭХ-ийн албан татвар	346.0	220.0	566.0	Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2016 оны 10-р сарын байдлаар Төв аймгийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл болон газар өмчлөгч, эзэмшигчийн судалгааг авч, үл хөдлөх эд хөрөнгийн ногдуулалтыг тооцоход 613.4 сая төгрөгийн татвар нөөц боломж байна. Үүнээс 2017 онд 346.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 220.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
2	Газрын төлбөр	1482.4	277.8	1760.2	Газрын төлбөр 2016 оны эхний 10 сарын байдлаар өссөн дүнгээр 1482.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс ХБГ-ээр 1412.1 сая төгрөгийн биелэлттэй гарахаар урьдчлан тооцсон байна. 2015 оны дутуу төлөлт 2016 оны эхэнд 350.4 сая төгрөг байснаас 10-р сарын байдлаар 115.8 сая төгрөг буюу 33.05 хувийг барагдуулж 234.6 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна. 2017 оны Газрын төлбөрийн суурь орлогын төлөвлөгөөний төслийг Сангийн яамнаас 1236.1 сая төгрөгөөр ирүүлснийг аймгийн Засаг дарга аймгийн ИТХ-д суурь орлогын саналыг 246.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1482.5 сая төгрөгөөр батлуулахаар өргөн барьсан байна. Газрын төлбөр нь 2013 онд 1084.5 сая төгрөг, 2014 онд 1168.1 сая төгрөг, 2015 онд 1728.0 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарч, 2016 оны ХБГ-ээр 1412.1 сая төгрөгөөр тооцож, 2017 оны төсвийн төсөлд тус төлбөрийг 1482.4 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2015 оны төлөвлөгөөнөөс 84.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлээс 245.6 сая төгрөгөөр тус тус бууруулан, 2016 оны ХБГ-ээс 70.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Иймд газрын төлбөрийн сүүлийн гурван жилийн төлөвлөгөө, түүний биелэлт, тайлант оны дутуу төлөлт 234.6 сая төгрөг байгаа зэргийг харгалзан 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Мөн аймгийн ИТХТ-ийн 2014.06.30 ны өдрийн “Газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 04 тоот тогтоолд Мал бүхий аж ахуй, байгууллага, иргэний бэлчээрийн төлбөрийг нэг хонин толгойд шилжүүлэн 231 төгрөгөөр тооцож авахаар баталсан. Уг тогтоолыг Бүрэн, Өндөрширээт, Лүн, Дэлгэрхаан сумдаас бусад сумдууд хэрэгжүүлээгүй байна. Аймгийн статистикийн тоон мэдээллийг ашиглан тооцоход жилдээ 426.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байгаагийн 30 хувиар тооцоход 127.8 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна. Нийт 277.8 сая төгрөгөөр газрын төлбөрийг нэмэгдүүлэх боломж байна.

3	Ус ашигласны төлбөр	1564.5	282.3	1846.8	Нийт ус ашиглагчийн 425 аж ахуйн нэгжээс чөлөөлөгдсөн 17 аж ахуйн нэгж, үйл ажиллагаа явуулаагүй 12 аж ахуй нэгж, иргэн , 132 аж ахуйн нэгж буюу 38.0 %-д ногдуулалтыг хийж, 264 аж ахуйн нэгж буюу 62.0 %-д ногдуулалт хийгээгүй байна. Жишээлбэл Заамар сумын усны ногдуулалтыг 27 аж ахуйн нэгж байхад 15 аж ахуйн нэгжид ногдуулалт хийсэн, Борнуур 41 аж ахуйн нэгж байхад 7 аж ахуйн нэгжээр ногдуулалт хийсэн, Батсүмбэр суманд 33 аж ахуйн нэгж байхад 8 аж ахуйн нэгжид ногдуулалт хийсэн, тариалангийн талбайнуудад ногдуулалт хийгээгүй байна. Усны нийт төлбөрийг аймгийн төсвийн орлогод 282.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Ус ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхдээ зөвхөн урьд оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцож нэмэгдүүлсэн. Мөн БОАЖГазрын усны мэргэжилтний нарийвчилсан судалгаагаар 10 сумын 79 ус ашиглагч байгууллагад ус ашигласны төлбөр ногдуулаагүй талаар тодруулга тайлбар ирүүлсэн. Жишээлбэл: Эрдэнэ сумын татварын байцаагчийн 2016 онд ус ашиглагчидад хийсэн ногдуулалтыг төсвийн төсөлд тусгахдаа -Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийг 17 аж ахуйн нэгжид 43.4 сая төгрөгөөр ногдуулалт хийсэнийг 14 аж ахуйн нэгжээр 34.2 сая төгрөг буюу 9.2 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.
4	Өмч хувьчлалы н орлого	40.0	80.0	120.0	Аймгийн ИТХТ-ийн 2010.03.03-ны өдрийн 30 тоот тогтоолоор хувьчлах шийдвэр гарсан ААН болон үйлдвэр, цехийн хөрөнгөнүүдээс төвлөрүүлээгүй үлдэгдэл 237.9 сая төгрөг, хувьчлагдсан орон сууц болон цөм сүргийн малын үнийн дутуу төлөлт 6.2 сая төгрөг нийт 244.1 сая төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна. Иймд өмч хувьчлалын орлогыг 80.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
5	Төсвт байгууллаг ын өөрийн орлого	82.1	8.3	90.4	Сумдын ЗДТГ-ын буудал, интернэт үйлчилгээний хөлсүүдийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор төлөвлөөгүй байгааг тооцож үзэхэд 8.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
6	Нэр зааж ангилагдаа гүй орлого	83.2	500.0	583.2	Аймгийн хэмжээнд 2003-2014 онуудад 388.3 мянган га газрыг 19.6 мянган иргэн аж ахуйн нэгж эзэмшсэн байна. Эдгээр газарт Газрын тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2012 оны 77 тоот тогтоол, Аймгийн Засаг даргаас “Хуулийн хэрэгжилт эрчимжүүлэх тухай” 2013 оны 08-р сарын 20-ны өдрийн а/448 тоот захирамж, 2013 оны 10-р сарын 15-ны өдрийн а/582 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжууд гарчээ. Үүний дагуу газрын дуудлага худалдааны анхны үнийг тооцож үзэхэд 2015 оны 11 сарын 01-ний өдрийн байдлаар газрын дуудлага худалдааны анхны үнэ сумдаас 12142.3 сая төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 2003-2014 онд олгогдсон газрын дуудлага худалдааны анхны үнэ 634.3 сая төгрөг, нийт 12776.6 сая төгрөгнөөс 2045.0 сая төгрөг төвлөрч 10731.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2015 онд газар эзэмших эрхийг цуцлахаар тооцсон 1670.8 сая төгрөг, асуудалтай иргэдийн 671.9 сая төгрөг, нийт 2342.7 сая төгрөгийн газрын дуудлага худалдааны анхны үнийг тодорхой шийдвэр гартал орох боломжгүй гэж үзээд хасч тооцвол 8388.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2017 оны төлөвлөгөөний төсөлд нэр зааж ангилагдаагүй орлогот газрын дуудлага худалдааны анхны үнийг тооцоогүй байна. 2011 оноос 2016 онд буюу сүүлийн 6 жилд жилд 100-600 сая төгрөг, жилд дундажаар 340.8 сая

					төгрөг төвлөрчээ. Иймд 2017 онд нэр зааж ангилагдаагүй орлогот газрын дуудлага худалдааны анхны үнээс 500.0 сая төгрөг орох боломжтой байна.
7	ОНХБорлу улсны орлого	40.0	300.0	340.0	Аймгийн ИТХ-ын 2010-2016 онд орон нутгийн өмчит хөрөнгийг худалдахаар шийдвэрлэсний дагуу хөрөнгө худалдан борлуулсан ч өнөөгийн байдлаар 403.1 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна. Иймд дутуу төвлөрүүлсэн хөрөнгийг 2017 онд төвлөрүүлэх боломжтой гэж үзэж орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Жишээлбэл: Зуунмод сумын Баянхошуу багт “Жишиг хороолол” байгуулах төсөл хэрэгжүүлэх тухай 2013 оны 03-р сарын 28 ны өдрийн А/153 тоот захирамжаар нефтийн задгайд суурьшсан айл өрхүүдийг Зуунмод сумын Баянхошуу багт нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хашааны газрыг өмчлөх, худалдан борлуулах шийдвэрийн дагуу "Баянхошуу" жишиг хорооллын хашаа худалдах, худалдан авах гэрээг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн 2015 оны 4 дүгээр 17-ны байдлаар 59 иргэнтэй гэрээ байгуулан 197.1 сая төгрөгийг төсөвт төлүүлэхээр гэрээ хийгдсэн байна. Үүнээс 2013-2014 онд нийт 53.0 сая төгрөг төлөгдөж 144.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2013-2014 онд тушаагдаж байсан Хот байгуулалт, барилгын албаны 140051002 тоот данс нь 2015 оноос хаагдсан тул хашааны мөнгө энэ онд ороогүй байна.
Дүн		3638.2	1668.4	5306.6	
Нийт орлого		4160.6	2194.6	6355.2	